

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ӨНӨӨГИЙН БА ХЭТИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Х. Цэдэнсодном

Манай орон зах зээлийн эдийн засагт орох эгзэгтэй үед хүн ам лүйн бодлого гарч байна. Ялангуяа хүн амын өсөлтийг харгалзан хүнс, түүхий эд, эрчим хүчний асуудлыг зохистой шийдвэрлэх, эрд олноо заруул, ажилгүйдэлд оруулахгүй байх үүднээс урьдчилан хэрсэн хүн амын бодлогыг явуулах шаардлагатай байна.

Ер нь 200.0 сая хүн амтай оронд явуулж байгаа зарим аграр арга хэмжээг 2 саяахи хүнтэй манай оронд шууд хэрэглэхэд боломжгүй нь мэдээж. Тухайлбал хүний өсөлтийг багасгах үзэл бодлыг өөрийн оронд шууд хэрэглэж болохгүй. Энэ үүднээс манай орны хүн амыг иж бүрэн судлах шаардлагатай өнөө үед хүн ам хурдан өсөөд байна гэвд түүний өсөлтийг хязгаарла. гэсэн үзэл байхгүй гэх баталгаа алга. Үүнтэй уялдаж, манай хүн амын өсөлтийг хязгаарлах бодит байдал манай оронд бий болсон уу? Энэ асуудлыг авч үзэхэд юуны өмнө аливаа сөрөг үзэгдлүүдийг урьдчилан харгах нь чухал. Үүнтэй уялдаж хүн амын өсөлт, түүний хурд ямар байх ёстой вэ? гэсэн асуулт гарна. Энэ үүднээс хүн амын өсөлт, хувьсал өөрчлөлт, орон зай, хөдлөлт зүй, нутаг дэвсгэрийн дэд бүтэц зэргийг судлах нь онол-практикийн чухал ач холбогдолтой.

Энэ асуудалтай холбогдсон зарим судалгааг дараах хэлбэрээр авч үзэхийг оролдов.

1. 1918-1989 онд монголын хүн амын өсөлт

Цэдэнсодном-ШУА-ийн Газарзүй нэвдэг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, газарзүйн ухааны дэд эрдэмтэн.

2. Хүн амын өсөлт, хөгжилтийн үе, шат тогтоох

3. Хүн амын өсөлтийн цар хүрээг /дээд, ердийн ба доод хэмжээг/ тогтоох.

4. Тус улсын хүн амын хэтийн төлөвийг боловсруулах /2010 оны байдлаар/

Энэхүү судалгааг явуулахдаа үнэмшил, нотолгоо бүхий хүн амын албан ёсны тооллогын материалыг ашигласан.

Судалгааны материалд шинжилгээ, үнэлэлт, дүгнэлт өгөхөд статистик-зураглалын аргыг хэрэглэв.

Манай орны хүн амыг тал бүрээс судалсан олон янзын материал байдаг. Жишээлбэл, НУБ-ын 1950-1983 оны хүн амын судалгаанаас үзэхэд, дэлхийн хүн ам дунджаар 184%-иар өссөн байхад, энэ хугацаанд манай хүн ам 200%-иас дээш өсөлттэй гэж бичигдсэн байх юм. Түүнчлэн манай орны хүн амын өсөлтийг Бразил, Колумба, Болив, Египет, Судан, Танзан, Алжир, Өмнөт Африкийн улсын хүн амын өсөлттэй ойролцоо гэж үзсэн байдаг.

Үүнтэй уялдуулж, 1950-1989 оны хүн амын өсөлтийг нарийвчлан судлахад манай хүн ам 110%-иас 274%-и хэлбэлзэлтэйгээр өссөн бөгөөд харин хүн амын дундаж өсөлт 180% байна. Энэ судалгааг дээрх судалгаатай харьцуулан үзэхэд манай хүн амын өсөлт дэлхийн хүн амын дундаж өсөлтөөс 4 пунктээр доогуур байгаа тул манай улс хүн амаа өсгөх нь зүйтэй болно. Энэ бүгдээс үзэхэд манай улсын хүн амын өсөлт өндөр байсан уу? гэсэн асуудал зүй ёсоор гарлаа. Судалгаанаас үзэхэд, 1925-1935 онд хүн ам 13, 3% буюу 87, 0 мянган хүнээр, 1950-1960 онд 10, 4% буюу 91, 0 мянган хүнээр, 1960-1970 онд 14, 8% буюу 261, 0 мянган хүнээр, 1970-1980 онд 18, 9% буюу 397, 0 мянган хүнээр өссөн байна. Түүнчлэн 1989 онд хүн ам 12, 3%-иар нэмэгдсэн боловч, 1979 онтой харьцуулахад хүн амын өсөлт 4, 7 пунктээр буурч буй зүй тогтол ажиглагдана. Цаашид хүн амын өсөлт буурах хандлагатай байгаа нь уг судалгаанаас харагдана. Тухайлбал, хүн амын албан ёсны тооллого явуулсан материалаас үзэхэд, хүн амын өсөлт тодорхой харьцаатай хэмжээгээр нэмэгдэж буй зүй тогтол ажиглагдаж байгаа явдал бол хүн амын энэ үзүүлэлтүүд нэлээд бодитой бол уу. Үүнээс гадна, нийгмийн хөгжил, түүний явцад гарсан зарим сөрөг үйл ажиллагааны нөлөөллөөс болж зарим жилүүдэд хүн ам өссөнгүй. Жишээ нь 1935-1945 онд хүн амын өсөлт огцом буурчээ. Энэ үед манай орны сэхээтнүүд, лам нарыг үй олноор хэлмэгдүүлснээс гадна, дэлхийн 2-р дайнд нэлээд хүмүүсээ алдсан зэрэг нөлөө бүхий шалтгаан бий. Энэ бүгдээс дүгнэлт хийхэд, 1938-1949 он бол манай хүн амын эрс бууралтын үе байжээ. Энэхүү судалгааны зарим дүгнэлтээс үзэхэд, 1950 оноос эхлэн манай хүн ам байнга өсөж иржээ.

Манай хүн ам жилд хэдэн хувиар өсөж байвал хамгийн тохиромжтой вэ? гэсэн асуудал байдаг. Хүн амын өсөлтийн арифметикний прогресс, түүний дундаж үзүүлэлтээс үзэхэд манай хүн амыг жилд 2, 4% өсөх явдал нь хамгийн тохиромжтой нөхцөл юм. Үүнээс үндэслэн хүн амын өсөлтийн цар хүрээ ямар байж болох вэ? гэсэн асуудал урган гарлаа.

Магадлын онолын үүднээс үзэхэд манай хүн амын өсөлт бууралтын цар хүрээ хүн амын өсөлтийн математик дундаж квадратыг гаргасан тооцоогоор бол байвал зохих алдаа $\pm 0,66$ байх нь тохиромжтой байна. Энэ судалгаанаас хүн амын хамгийн дээд өсөлт 3% хүртэл, харин хүн амын өсөлт нь 1, 8%-ийн өсөлтөөс доогуур байж болохгүй гэсэн хүн амын өсөлтийн зааг гарлаа. Үүнээс үзэхэд манай хүн амын өсөлтийг хязгаарлах асуудал байж болохгүй нь тодорхой байна.

Цаашид хүн амын зохистой өсөлтийг /1, 8%, 2, 4%, 3, 0%/ үндэслээд 1995, 2000, 2005 ба 2010 оны хүн амын хэтийн төлөвийг дараахи гурван хувиалбаргаар гаргав.

Манай орны хүн амын хэтийн төлөв /А. Б. В/

Хүн амын хэтийн төлөв /онуудаар/	Хүн амын тоо /мян. хүн/
1995 он	
А. Хэт өсөлттэй-3, 0%-иар	2292, 2
Б. Ердийн өсөлттэй-2, 4%-иар	2290, 1
В. Өсөлтийн дээд хэмжээ-1, 8%-иар	2268, 5
2000 он	
А. Хэт өсөлтийн-3, 0%-иар	2570, 5
Б. Ердийн өсөлт-2, 4%-иар	2553, 7
В. Өсөлтийн дээд хэмжээ-1, 8%-иар	2517, 7
2005 он	
А. Хэт өсөлттэй-3, 0%-иар	2882, 6
Б. Ердийн өсөлт-2, 4%-иар	2847, 7
В. Өсөлтийн дээд хэмжээ-1, 8%-иар	2794, 2
2010 он	
А. Хэт өсөлттэй-3, 0%-иар	3232, 6
Б. Ердийн өсөлт-2, 4%-иар	3175, 5
В. Өсөлтийн дээд хэмжээ-1, 8%-иар	2950, 7

Хүснэгтээс үзэхэд 2010 онд манай улсын хүн ам 3500000-д хүрч, өсөх хандлага бүрэн байна /1-р хувилбараар/. Түүнчлэн хүн амын хэтийн өсөлтийг илэрхийлсэн 1, 2-р хувилбар бол хүн ам аажмаар жигд өсөхийг илэрхийлсэн байхад, харин 3 дахь хувилбар бол хүн амын өсөлт огцом бууралтанд орж болохыг нотолж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд зөвхөн 2-р хувилбарыг манай хүн амын өвөрмөц онцлогт тохируулан, улам боловсронгуй болгон хэрэглэж болох юм. Ялангуяа бүс нутаг, аймаг, сум аж ахуйн хэмжээнд хүн амын хэтийн төлөвийг тооцоолоход хэрэглэх нь зүйтэй.

Хүн амын хэтийн төлөвийн энэ судалгаанд 1989 оны хүн амын албан ёсны тооллогын материал, ялангуяа манай хүн амын цэвэр өсөлтийн жилийн дундаж үзүүлэлт /2, 4%-ийг/ суурь материал болгон ашиглав.

Хүн амын прогнозын судалгаанд хүн амын нас, хүйсийн бүтэц, хүн амын нөхөн үйлдвэрлэл хийгээд байгаль, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг бүрэн хамааруулж чадаагүй учир дутагдал байгаа болзвч хүн амын цэвэр өсөлтийн дундаж үзүүлэлтийг үндэслэн хүн амын прогноз болдог НҮБ, бусад олон улсын туршлага дээр үндэслэж тооцооллыг явуулав. Цаашид хүн амын байршилтыг газарзүйн онцлогийг нутаг дэвсгэрийн хуваарилалтаар гүнзгийрүүлсэн судалгааг явуулах шаардлагатай байна. Харин дараах дүгнэлтийг урьдчилэн хийлээ.

1. Манай хүн амын өсөлтийн хурд их боловч манай хүний нийт тоо бага байгаа учир хүний тоо аажмаар нэмэгдэж буй энэ нөхцөлд хүнээ өсгөх бодлогыг явуулах нь зүйтэй, харин хүн амын өсөлтийг хязгаарлах үзэл бодол байж болохгүй нь нотлогдлоо.

2. Манай улсын 1918-1989 оны хүн амын өсөлтийг ерөнхийд нь дөрвөн үе шат болгож болох юм.

а/ Аажим буюу дунд зэргийн өсөлттэй үе. Энэ хөгжлийн шатанд манай 1918-1935 оны хүн амын өсөлтийг хамруулав.

б/ Хүн амын өсөлтийн нэн хурдтай үе. Энэ шатанд манай 1950-1979 оны хүн амын өсөлтийг эруулав.

в/ Хүн амын өсөлтийн бага зэргийн бууралттай үе. Энэ хөгжлийн шатанд манай 1985-1989 оны хүн амын өсөлт аажмаар буурч буй зүй тогтлыг хамруулав.

г/ Хүн амын өсөлт нэн бууралттай үе. Энэ манай 1938-1949 оны хүн амын тооны нэн бууралтыг хамаруулсан.

3. Хүн амын өсөлтийн дээд хэмжээ 3, 0%-наас бага байх, ердийн буюу дунд зэргийн 2, 4% байвал манай нөхцөлд хамгийн тохиромжтой хэмжээ бөгөөд харин хүн амын өсөлтийн доод хэмжээ 1, 8%-наас бага байж болохгүй гэсэн дүгнэлтэнд хүрлээ. /1989 оны байдлаар/

4. Хүн амын хэтийн төлөвийн судалгааг явуулснаар 20 гаруй жилийн тэртээд манай хүн ам 4000000 болно гэсэн таамаглалыг гаргаж байна.